

Мянган тогоруу:
АРНН-ий хамтаархи антологи

МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ СҮҮЛИЙН ХУГАЦАА

2020 оны 8 сарын 31

УДИРДАМЖ

1. Бүх шүлгийг 12 point Times New Roman форматаар .pdf эсвэл .docx хэлбэрээр ирүүлнэ.
2. Ирүүлэх материалдаа дараах зүйлсийг оруулна уу:
 - Овог нэр
 - Төрсөн он сар өдөр
 - Оршин суугаа улс
 - Харьяалагдах улсын нэр
 - Хэл
 - Богино танилцуулга (3-4 мөр)
3. 2021 оны 11-р сарын 10-13-ны хооронд Японы Кобе хотод болох Ази, Номхон далайн Хосписын бага хуралд танийг яруу найргаа толилуулахаар урьсан бол оролцох боломжтой бөгөөд сонирхож байгаа эсэхээ илэрхийлнэ үү. Аялал болон байраар хангана.
4. Дээрх зүйлсийг бэлдсэний дараа шүлгээ submission@athousandcranes.org хаягаар тус антологид орох шалтгаан болон (хэрвээ байгаа бол) хувийн паллиатив (хөнгөвчлөх) эмчилгээний ба/эсвэл амь насанд аюултай өвчинтэй тулгарсан тохиолоо товч тайлбарласан дагалдах захидал (cover letter) –ын хамтаар илгээнэ.

ИЛГЭЭХ

АНТОЛОГИЙН ТУХАЙ

Үхэл болон түүнийг давж гарах тухай сэдэв нь төдийлөн яригддаггүй боловч хүн бүрийн амьдралд тулгарах зугтаж боломгүй үнэн билээ. Үхлийн аюултай өвчинтэй нүүр тулгарсан өвчтөн, эсвэл түүний гэр бүлийн гишүүн, найз нөхөр, эсвэл эмнэлэгийн мэргэжилтэний хэн нь байлаа ч адилхан зүйлийг даван туулсан нэгний түүхийг сонсох нь нэгэн төрлийн тайвшрал болон хүчийг өгөх нь бий.

Sing Lit Station (SLS) болон Ази, Номхон далайн Хоспис Паллиатив Эмчилгээний Сүлжээ (APHN) нь энэхүү антологоор дамжуулан хоспис болон паллиатив (хөнгөвчлөх) эмчилгээний тухай ойлголтыг нэмэгдүүлж, мөн энэ сэдвийг тойрсон гүн гүнзгий яриа өрнүүлэхийг зорьж байна.

Паллиатив (хөнгөвчлөх) эмчилгээний ач тусыг хүртсэн Ази, Номхон далайн бүс нутагт амьдардаг бүх хүмүүс энэхүү антологид шүлэг, яруу найргаа ирүүлэхэд нээлттэй. Материалыг Ази, Номхон далайн бүс нутагт хэрэглэгддэг бүх голлох хэл дээр хүлээн авна.

ОРОЛЦОХ БОЛОМЖТОЙ БҮС НУТАГ: Австрали, Бангладеш, Бутан, Бруней, Камбож, Хятад, Хонг Конг, Энэтхэг, Индонез, Япон, Лаос, Малайз, Монгол, Мьянмар, Балба, Шинэ Зеланд, Номхон далайн арлууд, Пакистан, Филиппин, Сингапур, Солонгос, Шри-Ланка, Тайвань, Тайланд, Тимор Лесте, Вьетнам.

ЗӨВШӨӨРӨГДӨХ ХЭЛ: Англи, Бахаса Индонез, Бенгал, Бирм, Хинди, Япон, Солонгос, Малай, Мандарин, Монгол, Балба, Синхала, Тагалог, Тайланд, Вьетнам хэл

Шалгарсан бүх шүлгийг англи хэл рүү буулгана.

ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА

Ази, Номхон далайн Хоспис Паллиатив Эмчилгээний Сүлжээ (APHN) нь Ази, Номхон далайн орнуудад хоспис болон паллиатив (хөнгөвчлөх) эмчилгээг сурталчлан таниулах зорилготой юм. Тус байгууллагын зорилго нь амь насанд аюултай өвчинд нэрвэгдсэн хүмүүсийн зовлон шаналлыг нимгэлэх зорилготой байгууллага, хувь хүмүүсийг чадваржуулах, дэмжихэд оршино.

Энэхүү Сүлжээ нь боловсрол ба ур чадварын хөгжлийг дэмжих, ойлголт болон харилцаа холбоог сайжруулах, судалгаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.